

БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

2026 оны 02-р сарын 12-ны өдөр

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 29 ДҮГЭЭР ХОРОО НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН
СУУЦНЫ 141,143-Р БАЙРНЫ ФАСАДНЫ ӨНГӨ СЭРГЭЭХ АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ
БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

Улаанбаатар хот

№


2026.02.09.

| | | |
|----|-----------------------------------|--|
| 1. | Зураг төсөл боловсруулах үндэслэл | <ul style="list-style-type: none">- Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр- Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 49 дүгээр тогтоол |
| 2. | Барилга байгууламжийн байршил | <ul style="list-style-type: none">- 29 дүгээр хороо- 141, 143-р байр фасадны өнгө сэргээх |
| 3. | Зориулалт хүчин чадал | <ul style="list-style-type: none">- Нийтийн зориулалттай орон сууцны фасадны өнгө сэргээх |
| 4. | Төслийн гүйцэтгэх хугацаа | <ul style="list-style-type: none">- Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно. |
| 5. | Төслийн иж бүрдэл | <p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Тайлбар бичиг- Онцгой байдлын дүгнэлт- Эрүүл ахуйн Улсын байцаагчийн дүгнэлт /Шаардлагатай тохиолдолд/- Магадлалын нэгтгэсэн дүгнэлт /хавсралтын хамт/ <p><u>Зураг төсвийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Нүүр хуудас /Батлагдсан байх/- Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/- Хэмжилтийн зураг төсөл- Өөрчлөлтийн зураг төсөл- Барилгын төсөв /Магадлалаар батлагдсан байх/ |
| 6. | Зураг төсөл боловсруулах үе шат | <ul style="list-style-type: none">- Ажлын зураг төсөв нэг үе шаттай: Ажлын зураг, төсөв боловсруулж, батлуулах; |
| 7. | Зураг төслийн байгууллага | <ul style="list-style-type: none">- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих нөхцөл, шаардлага"-ын дагуу Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд; |
| 8. | Захиалагч байгууллага | <ul style="list-style-type: none">- Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын тамгын газар |

| | | |
|-----|---|--|
| | | - 29-р хорооны Засаг Дарга |
| 9. | Засвар хийгдэх ажлууд | <p><u>Фасадын өнгө сэргээх засвар хийх</u></p> <ul style="list-style-type: none"> - Гадна довжоо, саравчны засвар хийх фасадтай уялдуулан засаж, шинэчлэх. - Барилгын хаяавч, дээврийн парапетны төмөр засах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх. - Материал нь гарал үүслийн болон тохирлын гэрчилгээтэй, лабораторийн дүгнэлттэй байна. Гадна ханын гадаргууг бэлтгэх, цэвэрлэх, сул материалыг ховхолж авах, тэгш бус гадаргууг засаж тэгшлэх, хөрсжүүлэлт хийж суурь тавих - Барилгын гадна ханыг доод давхрын шалнаас дээврийн парапет ханын ирмэг хүртэл өнгийг сэргээнэ. - Цонхны хаялга төмрийг сайн чанарын материал ашиглан шаардлагатай хэсгийг шинэчлэх, шаардлага хангах хуучин төмрийг буцааж тавих - Борооны усны хаялгыг засварлаж, шинэчлэх - Гадна фасадын өнгийг ойр орчинтой зохицуулан хот байгуулалтын шаардлагад нийцүүлэх ба захиалагч, ашиглагчаас санал авахыг тайлбарт тусгах - Дээрх бүх ажлуудыг хийхэд дагалдан гарах шаардлагатай засварын ажлуудыг хийх. |
| 10. | Онцгой нөхцөл | <p><u>Засварын ажилд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none"> - Засварт ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн шинэ, чанартай тохирлын гэрчилгээтэй материал байх. - Материал нь гарал үүслийн болон тохирлын гэрчилгээтэй, лабораторийн дүгнэлттэй байна. - Борооны усны хаялгыг засварлаж, шинэчлэх - Гадна фасадын өнгийг ойр орчинтой зохицуулан хот байгуулалтын шаардлагад нийцүүлэх ба ашиглагчаас заавал санал авч тайлбарт тусгах - Засварын ажлын зураг төсвийг боловсруулахдаа ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэн протокол үйлдэж, хийгдэх ажлыг эрэмбийн дагуу төсөвт өртөгт багтах хэмжээгээр засварын ажлын зураг төсвийг боловсруулна. - Даацын бүтээцэд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж, ажлын зураг зурах; - Ажил эхлэх үед захиалагч болон ашиглагч байгууллагуудын холбогдох хүмүүст мэдэгдэж хийгдэх ажлын дараалал, хугацааг тодорхой болгож мэдээлнэ. - Төсвийг зохиохдоо заавал ажлын талбарт очиж, хэмжилт хийн фото зургаар баталгаажуулах. |
| 11. | Зураг төсөл боловсруулахад ашиглах материал | <p><u>Хууль тогтоомж:</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилгын тухай хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Олон нийтийн барилгын норм дүрэм /БНБД 31.03.03/; - Заслын ажил /БНБД 31-10-05/ - Барилга засварын ажлын төсвийн суурь нормууд - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм; - Барилгын гадна ханын металл тор бүхий шавардлагатай дулаан тусгаарлалтын ажлын техникийн дүрэм /БД 12-107-17/ |

| | | |
|-----|------------------------------|---|
| | | <ul style="list-style-type: none"> - Бусад холбогдох норм, дүрэм; <u>Стандартууд:</u> - "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000 - MNS 5830-2007 "Барилгын хуванцар цонх, хаалга" - MNS 5874-2008 "Цонх, хаалганы поливинилхлорид /PVC/ хэлбэржүүлсэн, цувимал эдэлхүүн" - "Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ" MNS 12.013-91 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - "Ажлын байрны хүчдэлийн түвшин" MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091 - Бусад холбогдох стандартууд; |
| 12. | Галын аюулгүй байдлын нөхцөл | <ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/ - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/ |
| 13. | Эдийн засгийн тооцоо, төсөв | <ul style="list-style-type: none"> - Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох. |

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ:



Д.МӨНГӨНДАЛАЙ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ИНЖЕНЕР:



Ц.ЭНХТӨГС